



ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2014 оны 05 сарын 18 өдөр

Дугаар А/275


Эрдэнэт


Хөрөнгө гаргах тухай

Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2016 оны 2 дугаар сарын 03-ны өдрийн “Монгол улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 батлах тухай” 19 дүгээр тогтоолын 2.1.6 –ийн зорилт-2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн ээлжит IV хуралдааны 2 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.МУИС-ийн Орхон сургуулийн оюутнуудад хөрөнгийн зах зээлийн талаар мэдлэг олгох сургалт болон Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг иргэд, аж ахуйн нэгж байгууллагад сурталчилан таниулах ажлыг зохион байгуулсугай.

2.Дээрх арга хэмжээнүүдэд шаардагдах зардлыг хавсралтаар баталж, 2650000 /Хоёр сая зургаан зуун тавин мянган/ төгрөгийг Засаг даргын хуваарилагдаагүй бусад зардлын “Санхүүгийн зах зээлд хөрөнгийн зах зээлийн эзлэх хувийг нэмэгдүүлэх хөтөлбөрийн хүрээнд орон нутагт сургалт, сурталчилгаа явуулах” зардлаас, 870000 / Найман зуун далан мянган/ төгрөгийг “Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, холбогдох дүрэм журмыг сурталчилах” зардлаас тус тус гаргахыг Санхүү, төрийн сангийн хэлтэс/ н.Бямбацэцэг /-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Д.БАТЛУТ



**ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЛЭГ ОЛГОХ СУРГАЛТЫН
ЗАРДЛЫН ТӨСӨВ**

№	Зардлын төрөл	Тоо хэмжээ	Нэгжийн үнэ	Нийт төсөв
1	Сургалтын төлбөр	110 хүн	20 000	2 200 000
2	Цайны завсарлагын зардал	120 хүн	3 000	360 000
3	Шатахуун		50 000	50 000
4	Бусад		40 000	40 000
	Нийт төсөв			2 650 000

ХУУЛЬ ТОГТООМЖ СУРАЛТЧИЛАХ ЗАРДЛЫН ТӨСӨВ

№	Зардлын төрөл	Тоо ширхэг	Нэгжийн үнэ	Нийт төсөв
1	НББ-ийн тухай, Аудитын тухай хуулийн танилцуулга, сургалтын слайд хэвлүүлэх	1200ш 1000ш	600 150	720000 150000
	Нийт төсөв			870000